



**ТӨР ЗАХИРГААНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ГАМШГААС ХАМГААЛАХ БОЛОН
ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ, СТАНДАРТ, НОРМ, НОРМАТИВЫН
БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨТ БОЛОН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ**

Нэг. Хяналт шалгалтын зорилго

Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль тогтоомж, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг төр захиргааны барилга, байгууламжид зохион байгуулж, болзошгүй эрсдэлийг бууруулахад оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1. Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, гал түймрийн улсын хяналтын дүрэм, бусад галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичиг нь уг шалгалтыг явуулах эрх зүйн үндэс болно.

2.2. Хяналт шалгалтад оролцох бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг болон энэхүү удирдамжийг баримтлан ажиллана.

2.3. Хяналт шалгалтыг зохион байгуулах явцдаа Коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас гаргасан тогтоол, шийдвэр, Улсын онцгой комисс, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тавьж байгаа заавар, зөвлөмж, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөх.

2.4. Төр захиргааны байгууллагын барилга барилга байгууламжуудад хяналт шалгалтыг зохион байгуулна.

2.5. Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчид нь хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалтыг гүйцэтгэж, илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил арилаагүй тохиолдолд Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл ноогдуулах, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.12.10 дахь хэсэгт заасан заалтыг хэрэгжүүлнэ.

2.6. Хяналт шалгалт хийсэн тухай мэдээллийг улсын хяналтын байцаагчийн өдөр тутмын ажлын мэдээний цахим бүртгэлийн программын мэдээллийн санд нэг бүрчлэн оруулсан байна.

Гурав. Хяналт шалгалт явуулах хугацаа, зардал

3.1. Хяналт шалгалтын нийслэлийн ажлын хэсгийг онцгой байдлын ерөнхий газрын мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн нар, орон нутгийн ажлын хэсгийг Онцгой байдлын газар, хэлтсийн дарга томилон удирдлагаар хангаж, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагч нар зохион байгуулна.

3.2. Томоохон төр захиргааны байгууллагын барилга байгууламжид хяналт шалгалтыг хийхдээ 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тушаалаар томилон ажиллуулна.

3.3. Хяналт шалгалт явуулахад шаардлагатай зардлыг тухайн орон нутгийн Онцгой байдлын байгууллага хариуцна.

3.4. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд тус тус явуулна.

3.5. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүн, мэдээг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор, гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүн, мэдээг 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн Hyanaltiinheltes.obeg@yahoo.com, Гамшгийн шуурхай удирдлагын газрын b.myagmarsuren@nema.gov.mn цахим хаягаар тус тус зөрчлийг фото зургаар баримтжуулан илтгэх хуудсын хамт ирүүлнэ.

Дөрөв. Хяналт шалгалтын үр дүн, авах арга хэмжээ

4.1. Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын вэб хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.

4.2. Онцгой байдлын ерөнхий газраас хяналт шалгалтын дүн, санал дүгнэлтийн талаарх танилцуулгыг шалгалтад хамрагдсан байгууллагуудын харьяалах төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шат дараатай авч хэрэгжүүлнэ.

4.3. Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүнг Гал түймэртэй тэмцэх газар нэгтгэн дүгнэж, Монгол Улсын Шадар сайд болон Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулж, холбогдох яам, агентлаг, газрын дарга нарт гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагчийн танилцуулга, мэдэгдэл, заавал биелүүлэх албан шаардлага хүргүүлэн биелэлтийг хангуулна.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР